



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 4/03

Мандалговь

“Аймгийн төвийн Дулааны станцын 2-р хэлхээний шугам, сүлжээний зураг төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авах комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Аймгийн төвийн Дулааны станцын 2-р хэлхээний шугам, сүлжээний зураг төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: О.Мөнхзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)


Гишүүд: Э.Энхмэнд (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч)

Э.Дүүрэнжаргал (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Тэмүүжин (“Тэмжин” ХХК-ийн захирал)

Хоёр. Аймгийн төвийн Дулааны станцын 2-р хэлхээний шугам, сүлжээний зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



У. ДОРЖБАТ

436710013